



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/141

Цагаан-Уул сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2024 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дэмжих ажлын хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байрны тохижилтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Дарга: У.Аварзэд (Засаг даргын орлогч)

Гишүүн: Ц.Оюунлхагва (Нийгмийн даатгалын байцаагч)

Нарийн бичгийн дарга: П.Отгонбат (Хөдөлмөр, халамж үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Техникийн тодорхойлолт бэлтгэх, урилга хүргүүлэх, үнийн санал хүлээн авах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж захиалагчид танилцуулж ажиллахыг ажлын хэсэг (У.Аварзэд)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнэцэцэг)-т даалгасугай.

ДАРГА

С.ГОНЧИГНЯМ

